

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2020 оны 03 дүгээр сарын 27 ны өдөр

Тендер шалгаруулалтын нэр: **Үнсний IY шугамын засварын ажил хийх**

Тендер шалгаруулалтын дугаар: **ДЦС-4/2020-37**

“ДЦС-4” ТӨХК нь эрх бүхий тендерт оролцогчдоос **Үнсний IY шугамын засварын ажил хийх** тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүйгээр татан авна уу.

Тендерт оролцогч нь тендер илгээхийн өмнө 100.000 /Зуун мянга/ төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 30 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

1. Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 2 жилийн жил тус бүрийн борлуулалтын орлого нь тендерт санал болгож буй үнийн дүнгээс багагүй байна. 2018, 2019 он тус бүрээр
2. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Тендерт санал болгож буй үнийн дүнгээс багагүй байна.
3. Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: сүүлийн 2 жил. 2018, 2019 он
4. Сүүлийн 2 жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: Тендерт санал болгосон үнийн дүнгээс багагүй байх /2018, 2019 он /
5. Тусгай зөвшөөрөл шаардлагатай эсэх: Шаардлагатай /7-40кгх/см²-аас дээш даралттай зуухны угсралт/

Тендерийн хамт Төсөвт өртгийн үнийн дүнгийн 2 %-тай тэнцүү дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Засгийн газрын бондоор ирүүлсэн тендерийн баталгааг хүлээн зөвшөөрнө.

Хүчинтэй байх хугацаа: 2020 оны 06 дугаар сарын 27-ний өдөр дуустал

Тендерийг 2020 оны 04 дугаар сарын 27-ны өдрийн 10.00 цагаас өмнө цахим системээр илгээх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2020 оны 04 дугаар сарын 27-ны өдрийн 10 цаг 30 минутад нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй, Дотоодын давуу эрх тооцохгүй.

Сонирхсон этгээд бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20 дугаар хороо, Эрчим хүчний гудамж, “ДЦС-4” ТӨХК-ийн Захиргааны байр, 3 дугаар давхар, 310 тоот өрөө Худалдан авах ажиллагааны хэлтэс Утас 7018-1309, 7000-1357, 7017-1357, Факс 7018-1309 7000-1357

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Ү.ТӨМӨРХУЯГ